

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
2019 ОНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хариуцах газар нэгж, албан тушаалтан
<b>Нэг. Шудрага, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b>				
1	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах,	1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн апбанд томилогдхоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд	- АТГ-аар 2019 онд тус яамнаас 21 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан бөгөөд цаасаар буюу хуучнаар ХАСУМ хянуулахаар илгээсэнбүх албан бичигт Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, Төрийн захиргааны албан хаагчийн тангаргийн хуудсын хуулбарыг бусад бичиг баримтын хамтхавсарган илгээсэн байна. - 2019 онд ХАСУМ хянуулсан бүртгэлийг яамны цахим хуудсанд байршуулав. Хавсралт № 03	ТЗУГ, ЭБАТ

	хариуцлагыг дээшлүүлэх	ил тод, нээлттэй болгох		
		2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	- 2019 оны 2 дугаар улирлаас Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянуулах үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн. - Цахим хэлбэрээр хянах ажиллагаанд шилжсэнээс хойш 9 ХАСУМ хянуулсан бөгөөд албан тушаалын тодорхойлолт, ХАСУМ-ийн баталгааны хуудсыг албан бичигт хавсарган илгээсэн байна.	
		3. Яамны төрийн албан хаагчдын нэрс ийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	- 2019 онд тус яаманд шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн болон төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн албан хаагчдын судалгаа, бүртгэлийг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланд хавсарган хүргүүлсэн. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус яамнаас өөрийн хүсэлтээр, суралцахаар чөлөөлөгдсөн 4, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул өөрийн хүсэлтээр 1, өөр газарт шилжин ажиллахаар хүсэлтээ өгч 2, бусад шалтгаанаар 1 албан хаагчуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Суралцахаар чөлөөлөгдсөн 4 төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэв. 2019 онд ТНБД 108 Б-тушаал гаргасан бөгөөд тушаалын нэгдсэн бүртгэлийг яамны цахим хуудсанд байршуулсан.	ТЗУГ, ЭБАТ
2	4.1.1.2. нийтийн албанд	4. Албан тушаалтанд тавигдах ёс	- Шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албаны шинэтгэлийн ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээрсарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Төрийнжинхэнэ албаны удирдах,	

	<p>томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>гүйцэтгэхалбантушаалдтавигдахтусгайшаардлагыг хангасан албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилж, дэвшүүлэн ажиллаж байна.</p> <p>- 2019 онд тус яаманд 10 албан хаагч томилогдсоны 8 нь төрийн албанд 5-25 жил ажилласан, төрийн албан хаагчийн тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчид юм.</p> <p>- Төрийн албаны шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн, төрийн албанд анх орох иргэдээс 2 иргэнийг сонгон шалгаруулж албан тушаалын сул орон тоог зохих журмы дагуу нөхсөн.</p> <p>- Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх ажлын хүрээнд УУХҮЯ ёс зүйн хороогоо шинэчлэн байгуулж, нийт албан хаагчиддаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулан гарын үсгээр баталгаажуулав.</p>	<p>Бүх газар, хэлтэс</p>
3	<p>4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх</p>	<p>5. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга</p>	<p>- 2019 онд албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээлэл гараагүй.</p> <p>- УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 19/01 дүгээр тогтоолын хавсралтаар гомдол санал хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг салбар зөвлөл ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулахаар шийдвэрлэсэн.</p>	<p>ТЗУГ, ХШҮДАГ, ЭБАТ</p>

	арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх		
4	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	6. Албан хэрэг хөтлөлтийн ABLE цахим системийг ашиглан бусад Төрийн байгууллагуудтай холбогдох боломжийг бүрэн ашиглах	<p>- Ажлын үр дүн, хариуцлагыг өндөржүүлэх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, төрийн болон бусад байгууллагуудтай шууд харицах боломжтой албан хэрэг хөтлөлтийн ABLE цахим <a href="https://intranet.gov.mn/">https://intranet.gov.mn/</a> системд шилжин Засгийн газрын албан хэрэг хөтлөлтийн программыг үйл ажиллагаандаа хэрэглэн ажиллаж байна.</p> <p>- ABLE программыг бүрэн ашиглах, ажлын үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж байна. Тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөнд давхар тусган, жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн байна.</p> <p>- Ашигт малтмал, газрын тосны газартай дотоод сүлжээгээр холбогдон геологийн зураглалын ARCGIS программыг ашиглаж байгаа нь ажлыг хурдтай гүйцэтгэх, цаг хэмнэх, ил тод байдлыг хангах зэрэг олон талын ач холбогдолтой байна.</p>	ТЗУГ
5	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	7. АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулагдах бүх сургалтад албан хаагчдыг жигд оролцуулах	АТГ-ын Олон нийтийн төвд 2019 оны 1-р улиралд зохион байгуулсан сургалтад 4 албан хаагч оролцсон.	ТЗУГ, ЭБАТ
		8. УУХҮЯ-ны албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөнд Авилгын эсрэг болон төрийн албан хаагчийн ёс	<p>УУХҮЯ-ны албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөнд авлига, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв хандлага төлөвшилтэй төрийн албан хаагчийг бэлтгэх зорилготой</p> <p>-Төрийн захиргааны удирдлага, хандлага, төлөвшил, төрийн албан хаагчийн ёс зүй</p> <p>- Монгол төрийн түшмэл уламжлал, хөгжил</p> <p>-Хяналт шинжилгээ үнэлгээний шинэ арга механизм зэрэг сургалтуудыг төлөвлөн сургалтад яамны нийт албан хаагчид оролцов.</p> <p>- Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн 64.3-т</p> <p>Засгийн газрын Хэрэгэрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан</p>	ТЗУГ, ЭБАТ

		зүй, хандлагыг төлөвшүүлэх бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтуудыг тусган батлуулах, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулах	сургах, төрийн албаныхүнийнөөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээхийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөхүндсэнүүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллана гэж заасан. Энэ заалтын дагуу Удирдлагын академийн дэргэд Төрийн албаны сургууль байгуулагдан, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлсэн. - 2019 онд Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан тэргүүн түшмэлийн багц сургалтад Төрийн нарийн бичгийн дарга, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 13 нэгжийн дарга, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 8 ахлах мэргэжилтэн тус тус хамрагдсан.	
<b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
6	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	9. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөөний гаргаж, төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхийн тулд дотоод сүлжээ, түүнд ашиглагдаж буй программ хангамжийг шинэчлэх ажлын төлөвлөгөө төсвийг боловсруулан батлуулж, 10-р сард яамны засварын ажлын хамт гүйцэтгэж дуусгалаа.	ТЗУГ
		10. Яамны цахим сүлжээнд авилгын эсрэг төлөвлөгөөг байршуулах, санал,	“Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан яамны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудсанд байршуулсан. Иргэд олон нийтээс санал сэтгэгдэл хүлээж авах бүх боломж хангагдсан.	ТЗУГ, ХШҮДАГ

		сэтгэгдэл хүлээж авах боломжийг бүрдүүлэх, утас, цахим хаяг тавих		
7	4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	11. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Хяналт шалгалт хийх объектийн эрсдлийг урьдчилан тодорхойлж, жил бүрийн эхэнд дотоод аудитын төлөвлөгөөг сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>- Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын тайланг хагас жил тутам авч эрсдлийг тооцон зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн хяналт дотоод аудитыг зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>- АМГТГ, “Эрдэнэс таван толгой” ХК-д байгууллагын дотоод хяналтын албадтай хамтран дотоод аудит хийх байнгын удирдамжийг УУХҮСайдаар батлуулан аудит хийлээ.</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/51 дүгээр тушаалаар батлагдсан байнгын удирдамжийн хүрээнд АМГТГ-т “Нөөцгүй болон нөөц тодорхойгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл”, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл”-ийн байдалд тус тус нийцлийн аудит хийж 10 заалттай зөвлөмж хүргүүлсэн.</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 19 заалттай зөвлөмж хүргүүлж зөвлөмжийнбиелэлтийг хангуулан ажиллав.</li> </ul>	ТЗУГ, ХШҮДАГ
<b>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
	4.1.3.3. Засгийн	12. Яамны санхүүгийн	- Шилэн дансны тухай хуулийн дагуу УУХҮЯ-ны санхүүгийн мэдээллийг цаг тухай бүр нь <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> сайтад байршуулан ажиллаж байна.	

	газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх	- Сайтад байршуулах шаардлагатай бүх мэдээллийг цаг тухай бүр нь 100%байршуулсан. - 2019 онд УУХҮЯ Засгийн газрын тусгай сангаас ямар нэгэн санхүүжилт аваагүй.	
<b>Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
8	4.1.6.5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах	13. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	<p>- “Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан”-г Монгол улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр “Астериск техноложис” ХХК <a href="http://asterisk-tech.mn">http://asterisk-tech.mn</a>/боловсруулсан.</p> <p>Хэрэглэгч мэдээллийн сангаас хүссэн аймаг орон нутаг, эрдсийн төрөл, гэрээний төрөл, компаний нэрээр хайлт хийн мэдээлэл авах боломж бүрдсэн.</p> <p>- “Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан”-д нийт 583 гэрээ, 162 гэрээний заалтын тайлбар, 8 хууль тогтоомж бүртгэгдсэн байна.</p> <p>- УУХҮ-ийн сайд, удирдлагууд сар бүрийн сүүлийн 7 хоногт УУХҮЯ дээр “Ил тод хариуцлагатай уул уурхай” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулдаг бөгөөд салбарын асуудлаар ил тод мэдээлэл өгдөг.</p>	Бүх газар, хэлтэс
		14. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн	- Монгол Улсын эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор Нээлттэй нийгэм Форум (ННФ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) зэрэг байгууллагууд хамтран эрдэс баялагийн гэрээний мэдээллийн санг бий болгосон. Энэхүү ажлын хүрээнд газрын тосны хайгуул, ашиглалтын нийт 26 Бүтээгдэхүүн хуваах гэрээний эх бичвэрийг <a href="http://iltodgerree.mn">iltodgerree.mn</a> сайтад байршуулсан болно.	ТЗУГ

	хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах		
	14. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниуд жил бүр “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г БОАЖЯ-аар батлуулж, төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэдэг. 2019 оны БОМТ-г БОАЖЯ-наас энэ оны 7, 8 дугаар сард батлагдсан. 2019 оны 9 дүгээр сарын 20-ны байдлаар Байгаль орчны ажил дараах явцтай байна. Үүнд:</p> <p><u>Тосон-Уул XIX талбайд</u> ахуйн шингэн хаягдлыг цэвэршүүлэх байгууламжийн шинэчлэл, өрмийн шаврын санд техникийн нөхөн сэргээлт хийх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, хатуу хог хаягдлын менежментийн ажлууд хийгдэж байна.</p> <p>Байгаль орчны мониторинг хийх, Биологийн нөхөн сэргээлт хийх, ургамалжуулах, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх, Дүйцүүлэн хамгаалал, Гүний усны мониторингын багаж суурилуулах зэрэг ажлууд гэрээлэлтийн шатанд явж байна.</p> <p><u>Тамсаг XXI талбайд</u> Замын тэмдэг, тэмдэглэгээ тавих ажил хийгдэж дууссан. Биологийн нөхөн сэргээлт, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг саармагжуулах, нөхөн сэргээх, ариутгал халдваргүйжүүлэлт, хөрсний дээж авах, шинжлүүлэх хийгдэж байна.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүйцүүлэн хамгаалалт зэрэг ажлууд гэрээний шатанд явж байна.</p> <p><u>1997 оны БХГ-т талбайд</u> дүйцүүлэн хамгаалах ажил хийгдэж дууссан. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байна.</p>	ТЗУГ, ХҮГТБЗГ, ХХ
	15. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулсан.</p> <p>- “Эрдэсбаялгийн салбарташигхүртэгчэцсийнээздийгилболгох” 2020 онхүртэлхтөлөвлөгөөболовсрууланажиллажбайна. ОҮИТБС-ынжилбүрийннэгтгэлийнтайлангаар 2013 оноосхойш 200 гаруйкомпаниудсайндурарээрэээмшигчийнмэдээллээтайлагнаадбайна.</p> <p>- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд Улууурхай, хүндүйлдвэрийнсайдын 2019оныА/82 дугаартушаалаарЭрдэс баялгийн салбарын ил тод байдлынтухайхуулийнтөслийгболовсруулахажлынхэсэгбайгуулагдаж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох судалгааг хийж байна.</p> <p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлынтухай хууль батлагдснаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал хангагдах боломж бүрдэнэ.</p>	ХҮГТБЗГ



			- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/13 дугаар тушаалаар Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим сангийн үр нөлөө, тогтвортой ажиллагааг дэмжих хүрээнд Газрын тосны эрлийн гэрээ болон Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бичил уурхай эрхлэгч нөхөрлөлтэй байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох ажлыг ажлын хэсгийн хүрээнд бэлтгэл ханган, цахим санд байршуулахад бэлэн болгоод байна.	
<b>Арав. Шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
9	4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	16. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлын хүрээнд АТГ-аас шинэчлэн хэвлүүлсэн “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг олшруулан нийт албан хаагчид болон иргэдэд 50 ширхэгийг тарааж, судлах, сурталчлах ажлыг зохион байгуулав.	ТЗУГ, бүх газар хэлтэс
		17. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахажлын хүрээнд давхар ажил эрхлэлт, хамаарал бүхий этгээдийн судалгаа, ХАСУМ хянуулсан судалгаа, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэх бүртгэл зэрэг судалгаа, мэдээллийн санг бий болгосон. - Тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэв.	ТЗУГ, ЭБАТ
<b>Яамны эрхлэх ажлын хүрээнд</b>				
10	Давхар ажил эрхлэх боломжтой	18. Хуулиар болон бусад холбогдох	Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулав.	ТЗУГ, ЭБАТ

	эсэхийг шийдвэрлэх	байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулах		
		19. Давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргаж, АТГ-д хүргүүлэх	2019 онд давхар ажил эрхэлсэн буюу компаний Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж буй албан хаагчдын мэдээлэл, судалгааг шинэчлэн хавсаргав. Хавсралт №04	ТЗУГ, ЭБАТ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

М.БАЯРАА

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.БАТБОЛД

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХҮНД ҮЙЛДВЭР, ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Б.АНХБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ГАНХҮҮ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТЗУГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ ШИНЖЭЭЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Ш.УРАНЧИМЭГ